


ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

**АН АМЬТДЫН АМЬДРАХ ОРЧНЫГ ХАМГААЛЖ, СЭРГЭЭН НУТАГШУУЛАН ТОО
ТОЛГОЙГ НЭМЭГДҮҮЛЭХ АЖЛЫН ДААЛГАВАР, ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ**



| Тарвага барих | Шалгуур |
|--|--|
| нутагшуулах аж ахуйн нэгж | Байгаль орчны чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх мэргэжлийн байгууллагын гэрчилгээтэй байх |
| байгууллагыг сонгон | Тарвага барих, зөөвөрлөх, тээвэрлэх ажилд шаардлага хангасан багаж хэрэгсэл, техник, тоног төхөөрөмжтэй байх |
| шалгаруулахад харгалзах үзүүлэлтүүд | Үйл ажиллагаа явуулах санхүүгийн чадавхитай байна. /Аудитын дүгнэлт, татварын тодорхойлолт, харилцагч банк, шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн тодорхойлолт/ |
| Бэлтгэл ажил | Тарвага барих сумын Засаг даргатай гэрээ байгуулж Байгаль орчин, аялал жуулчлалын яамнаас тогтоосон төлбөр хураамжийг төлсөн байх |
| | Тарваганы нүх бүрийг тогтмол шалгаж, гэмтээхгүй барих, хадгалах, тодорхой хугацаанд хорогдол гаргахгүй тээвэрлэх ажлын график, төлөвлөгөө гаргах |
| | Тарвага тус бүрийг түр хадгалах, тээвэрлэх торон хайрцгийг бэлтгэх, тээврийн хэрэгслээр зөөх үед хайрцаг хөдөлгөөнгүй байхаар бэхлэх |
| Үндсэн ажил | Тарвага нутагшуулах болон авах газрын ургамлын төрөл зүйл, газар зүйн онцлогийг судалж ойролцоо газрыг сонгох |
| | Нутагшуулах тарваганы тоо 30-аас доошгүй байх шаардлагатай |
| | Сумын байгаль хамгаалагчийн хяналтан дор тарвага барих ажлыг зохион байгуулах. |
| | Барьсан тарвагыг технологийн дагуу хадгалан, тээвэрлэх ажлыг хийж гүйцэтгэх |
| | Нутагшуулсан тарвагыг хариуцан хамгаалах нөхөрлөл, иргэнийг ажиглалт хийх багаж хэрэгслээр хангах, тарваганы амьдралын онцлог, төллөлт, ажиглалт тандалт хийх арга зүй, тоолох арга зүй, байгаль дээр байхдаа үзүүлэх ач холбогдол зэргээс бүрдсэн сургалт зохион байгуулах. |
| | Цаашид шинээр нутагшуулсан тарваганы амьдрах орчны таатай байдал, хууль бус агналтад байнгын хяналт тавьж хэвийн өсөлтийг хангах ажлыг үе шаттайгаар зохион байгуулах маршрут, график гаргах. |
| Тухайн жил нутагшуулсан тарваганы шилжилт хөдөлгөөн, төллөлт, нутагшсан байдал, тооллогыг 3-аас доошгүй сарын дараа дахин хийж дүгнэлт гаргах. | |

| | |
|------------------|---|
| Ажил хүлээж авах | Тарвага нутагшуулахдаа аймгийн Засаг даргын захирамжаар байгуулагдсан ажлын хэсэг, цаашид хариуцан хамгаалах нөхөрлөл, айл өрхүүдтэй гэрээ байгуулан актаар хүлээлгэж өгнө. |
|------------------|---|